



ҮЙЛДВЭРЛЭЛ, ХУДАЛДААНЫ "СҮҮ" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 08 сарын 18 өдөр

Дугаар 18

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 6 дугаар бүлэг, 76 дугаар зүйлийн 76.1 дэх хэсэг, "Сүү" ХК-ийн дүрмийн 8 дугаар бүлгийн 8.15 хэсэг, 11 дүгээр бүлэг болон 2026 оны 08 сарын 12-ны өдрийн "Сүү" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Сүү" ХК-ийн 2026 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас 2,830,840,295.3 /Хоёр тэрбум найман зуун гучин сая найман зуун дөчин мянга хоёр зуун ерэн таван төгрөг гучин мөнгө/ төгрөгийг нийт хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон олгохыг зөвшөөрсүгэй.
2. "Сүү" ХК-ийн нэгж хувьцаа тус бүрд 8.25 /Найман төгрөг хорин таван мөнгө/ төгрөгийн ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр олгож, ногдол ашгийг тараах, түүнтэй холбоотой ажлыг зохион байгуулах, холбогдох баримт бичигт компанийг төлөөлөн гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал /Б.Гантулга/-д олгосугай.ы
3. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 09 сарын 26-ны өдрөөр тогтоосугай.
4. Ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэд 2026 оны 12 сарын 31-ний өдрийн дотор тарааж дуусгасугай.
5. Энэхүү шийдвэрийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг Гүйцэтгэх захирал /Б.Гантулга/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ГАНБААТАР